

СУРГУУЛИЙН хүлээх үүрэг

1. Асфальтан хучилттай – баталгаатай замаар, Улаанбаатар хотод доторх төв замын гол зогсоолууд дээр сурагчдыг өглөөдөө авч, үдээс хойш буулгах зорилгоор автобусны маршрут, цагийг тогтоож үйлчилгээ үзүүлнэ.
2. Автобусан дотор хариуцлагатан багш томилогдон ажиллана.
3. Автобусны үйлчилгээ, аюулгүй байдлыг хангах хяналтыг тавьж ажиллана.

СУРАГЧ-ийн хүлээх үүрэг, хариуцлага

1. Сурагч автобус хөдлөхөөс өмнө суудлаа эзэлсэн байх ёстой.
2. Сурагч нь автобусанд суух бүртээ автобусны билетээ жолоочид заавал шалгуулна
3. Сурагч автобусны билетээ бусдад шилжүүлэхийг хориглоно.
4. Сурагчид хоорондоо нам дуугаар ярилцаж, зөв, боловсон үг яриа хэрэглэнэ.
5. Автобусан дотор юм идэж, уухыг хориглоно.
6. Улирлын байдлаас шалтгаалж журам сахиулагчийн зөвшөөрлөөр цонх онгойлгоно. Харин толгой, гараа автобусны цонхоор гаргахыг хориглоно.
7. Сурагч биеэ зөв, зохистой авч явж, жолооч, багш болон автобусаар үйлчлүүлж буй бусад сурагчиддаа хүндэтгэлтэй хандана. Энэхүү журмыг удаа дарааллан зөрчсөн сурагчийг сургуулийн захиргаанд мэдэгдэж автобусанд суулгах эрхийг хасуулах хүртэл арга хэмжээ авна.
8. Сурагч нь автобусны билетээ сурагчийн үнэмлэхийн хамт биедээ тогтмол авч явна.
9. Автобусанд хувцасаа солих, амьтан авч явахыг хориглоно.
10. Шовх үзүүртэй, хурц иртэй болон хагарамтгай зүйлсийг биедээ авч явахыг хориглоно. Хичээлийн хэрэгсэл (бал, үзэг, шугам гэх мэт) ба тоглоомоо цүнхэлж явах шаардлагатай.
11. Сурагч өглөө тогтсон цагаас 10 минутын өмнө автобусны зогсоол дээр ирсэн байна.
12. Сурагчийг зөвхөн сургууль дээр буулгаж, гэртээ харихад нь тогтсон зогсоол дээр буулгана. Тухайн автобусанд зорчих бүртгэлгүй хэн нэгнийг автобусанд суулгахыг хориглоно.
13. Автобусыг өөрийн өмч хөрөнгө шиг хайрлан хамгаалах ёстой.
14. Сурагчид автобуснаас бугаад зам хөндлөн гардаг бол автобуснаас 3 метрийн зай барьж гарах шаардлагатай
15. Автобусны хөдөлгөөн бүрэн зогсосны дараа сурагч автобуснаас бууна.

ЭЦЭГ ЭХ -ийн хүлээх үүрэг, хариуцлага

1. Хуваарийн дагуу автобус хөдлөхөөс 10 минутын өмнө (бага ангийн сурагчдад хамаарна) эцэг эх сурагчыг автобусны зогсоол дээр хүргэж ирсэн байх.
2. Тогтсон зогсоол дээр сурагчийг /бага ангийн сурагчдад хамаарна/ тосож авдаг хүн нь байхгүй бол жолооч эцэг эхийг холбоо барьтал сурагчийг буулгалгүйгээр цааш маршрутаа үргэлжлүүлэн явна.
3. Эцэг эхчүүд аливаа гомдол саналаа багш, жолоочтой шууд харьцалгүйгээр сургуулийн захиргаатай 345359, 348888 утас, info@asu.edu.mn хаягаар холбоо барьж хэлнэ.
4. Ямар нэгэн шалтгаанаар автобусаар үйлчлүүлэхгүй тохиолдолд автобусыг зогсоол дээр дэмий хүлээлгэхгүйн тулд урд өдөр нь сургуулийн захиргаа эсвэл жолоочид мэдэгдсэн байна.
5. Хэрвээ таны хүүхэд суух цагаасаа байнга хоцордог бол жолооч сургуулийн захиргаанд мэдэгдэнэ. Энэ байдал удаан үргэлжилбэл хүүхдээ өөрөө сургуульд нь зөөхийг сургуулийн захиргаанаас эцэг эхэд санал болгоно.
6. Автобусны бүрэн бус байдал болон жолоочийн хариуцлагагүй байдлаас болоод автобусанд сууж чадалгүй өөр тээврийн хэрэгслээр явсан тохиолдолд эцэг/эх таксины мөнгө сургуулиас нэхэмжлэх эрхтэй.
7. Хүүхэд автобусанд аливаа хохирол учруулсан бол эцэг/эх хохирлыг барагдуулна.
8. Автобусны төлбөрийг жилд хоёр удаа, семестр бүрт хийнэ. 1-р семестрийн төлбөрийг 8-р сарын 25-ны дотор, 2-р семестрийн төлбөрийг 1-р сарын 25-ны дотор төлсөн байна.
9. Автобусанд суухаа болих тохиолдолд сургуулийн захиргаанд 2 долоо хоногийн өмнө урьдчилж мэдэгдэнэ.
10. Автобусны үйлчилгээг авч байгаад гэнэт зогсоосон тохиолдолд төлбөрийн буцаалт авсан өдрөөс үл хамааран үлдэгдэл төлбөрийн 75%-ийг буцаана.
11. Хэрэв сурагч удаа дараа автобусны дотоод журмыг зөрчиж, автобусанд суух эрхээ хасуулсан бол төлбөрийг буцаан олгохгүй.
12. Хэрэв тухайн автобусанд суудал байгаа тохиолдолд нэг талдаа суух сурагчийг өвшөөрнө. Төлбөрийг нийт төлбөрийн 70% тай тэнцүүлж тооцно.
13. Автобус бүрт хариуцсан багш явна.
14. Өргөдөл гаргаж буй сурагч хоёр долоо хоногийн өмнө автобусанд суух өргөдлөө өгсөн байна.